

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны  
сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл Намын

Мөрийн хөтөлбөр

Ерөнхий зүйл: УИХ-н 2020 оны ээлжит сонгуульд "ШИНЭ нам, Бүгд Найрамдах нам, Үнэн ба Зөв нам, Монгол Үндэсний Ардчилсан намуудын **ШИНЭ ЭВСЭЛ**"-ээс дэвшүүлсэн "**ШИНЭ ЭРГЭЛТИЙН БОДЛОГО-21**" мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхийг үндсэн зорилтоо болгон ажиллана.

**Хамтдаа хөгжих 10 зорилт:**

1. Орон нутагт намчирхал, талцалыг таслан зогсооно.
2. Орон нутгийн төсвийн зарцуулалтад хатуу хяналт тогтооно.
3. Аливаа асуудал, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхдээ тухайн орон нутгийн иргэдэд мэдээллийг урьдчилан танилцуулж, нээлттэй, өргөн хэлэлцүүлэг хийсний дараа шийдвэр гаргадаг жишгийг тогтооно.
4. Орон нутгийн ИТХ, Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг мэдээллийн бүхий л хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан тогтмол мэдээллэж, байнгын, бодит, өгөөжтэй эргэх холбоог бий болгоно.
5. Тухайн орон нутгийн иргэдийн хамтарч, хоршиж ажиллах аливаа санал, санаачлагыг дэмжиж ажиллана.
6. Иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, хялбар, энгийн ойлгомжтой болгох талаар төрийн захиргааны байгууллагууд болоод тухайн тойргоос сонгогдсон УИХ-н гишүүдтэй нягт хамтран ажиллана.
7. Нийтийн өмч, зам талбайн ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуйн нөхцөл байдал, орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтад тухайн орон нутгийн иргэдийн сайн дурын оролцоог эрс нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
8. Төв суурин газрын гудамж, орчны тоосжилтыг эрс бууруулах талаар иргэдийн оролцоонд суурилсан санаачлага гарган ажиллана.
9. Хүүхдийн тоглох, суралцах орчины эрүүл, аюулгүй орчныг хангах зорилтыг тэргүүлэх бодлого болгоно.
10. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс үзүүлдэг халамжаас гадна тухайн орон нутгийн иргэд хамтран сайн дурын үндсэн дээр нэгдэж халамж туслалцаа үзүүлдэг тогтолцоог хэвшүүлэх ажиллагааг санаачлан эхлүүлнэ.

